



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 618

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2018 оны 53/2018/, 48/2018, 2018/20 дугаар акт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.3, 4.4 заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 1,228,025,034.00 (нэг тэрбум хоёр зуун хорин найман сая хорин таван мянга гучин дөрвөн) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Увс аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 94,709,779.00 (ерэн дөрвөн сая долоон зуун есөн мянга долоон зуун далан есөн) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Архангай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 91,999,895.00 (ерэн нэгэн сая есөн зуун ерэн есөн сая найман зуун ерэн таван) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

4. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, Увс аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга Б.Пүрэвсүрэн, Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга Е.Дандарваанчиг, Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга Ч.Оюунчимэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

4.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

4.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

4.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

5. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001172

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 12-дрийн
618 дугаар тогтоолын хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХАРЬАА БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)
Увс аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв						
1	Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний барилга	2018	ш	1	1,228,025,034.00	1,228,025,034.00
Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв						
2	Архангай аймгийн Тариат сум цаг уурын өртөөний барилга	2018	ш	1	94,709,779.00	94,709,779.00
Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв						
3	Баянхонгор аймгийн Баянговь сумын Цаг уурын өртөөний барилга	2018	ш	1	91,999,895.00	91,999,895.00
	ДҮН			3	1,414,734,708.00	1,414,734,708.00
	НИЙТ ДҮН				(нэг тэрбум дөрвөн зуун арван дөрвөн сая долоон зуун гучин дөрвөн мянга долоон зуун найман)	